

Иргэний нислэхийн өрөнхий газрын даргын
2019 оны // дүгээр сарын // -ий өдрийн
// дүгээр тушаалын хавсралт

НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДАД
МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

Нислэгийн удирдагчдын мэргэжлийн дадлага, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, ажилтнуудын ур чадварын шалгаруулалтын байнгын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлснээр нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аюулгүй ажиллагааг сайжруулах шаардлагын хүрээнд боловсруулагдсан болно.

Нэг.

1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнуудын ажлын байранд сонгон шалгаруулах, томилон ажиллуулах шаардлагын хүрээнд үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Еренхий зүйл

2.1 Мэргэжлийн зэрэг нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажлын байр, албан тушаалтуудад хүний нөөцийг сонгон шалгаруулах, томилон ажиллуулах үндсэн шалгуурын нэг байна.

2.2 Мэргэжлийн зэргийн шаардлага ажилтнуудад ижил тэгш тавигдана.

2.3 Мэргэжлийн зэрэг горилох, шалгалт авах, олгох үйл ажиллагаа энэхүү журмын дагуу зохицуулагдах ба энэхүү журамд заагдаагүй нөхцөл байдал үүссэн үед мэргэжлийн зэргийн шалгалтын комисс хэлэлцэн шийдвэрлэнз.

2.4 Ажлын байруудад ялгаатай тогтоосон цалингийн сүлжээ болон энэхүү журмын 7 дугаар зүйлд заасан мэргэжлийн зэргийн нэмэгдэл нь мэргэжлийн зэрэг авахаар горилох, нислэгийн удирдагч нар ур чадвараа байнга дээшлүүлэх үндсэн хөшүүрэг болно.

Гурав. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажлын байрны
мэргэжлийн зэргийн шаардлага

3.1 Ахлах болон багш нислэгийн удирдагчийн ажлын байранд ажиллах нислэгийн удирдагч нь мэргэжлийн II, I зэрэгтэй байна.

3.2 Еренхий нислэгийн удирдагч, хэсэг, тасгийн ахлагч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний мэргэжилтэн, удирдах албан тушаалтан нь мэргэжлийн I дүгээр зэрэгтэй байна.

Дөрөв. Мэргэжлийн зэрэг горилогчид тавигдах шаардлага

4.1 Мэргэжлийн зэрэг горилогчид дараах үндсэн шаардлагууд тавигдана.
Үүнд:

4.1.1 Мэргэжлийн III зэрэг авахад;

а. Нислэгийн удирдагч мэргэжилтэй, хучин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, зэрэглэлтэй байх;

б. Нислэгийн удирдагчийн үнэмлэх, зэрэглэлийн дагуу 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;

5.4 Мэргэжлийн зэргийн шалгалтын комиссын бүрэлдэхүүн тест боловсруулж, баталгаажуулж, нууцлал хадгалах үүрэг хүлээнэ.

5.5 Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь шалгалтын дүн, үйл ажиллагааны тайланг Иргэний нисэхийн еренхий газрын даргын зөвлөлд тайлагнана.

Зургаа. Мэргэжлийн зэргийн шалгалт

6.1 Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь мэргэжлийн зэргийн шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

6.2 Мэргэжлийн зэргийн шалгалтын зарыг шалгалт эхлэхээс 2 сараас багагүй хугацааны өмнө зарлан мэдээлсэн байна.

6.3 Мэргэжлийн зэргийн горилогчийг шалгалт эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө бүртгэж дууссан байна.

6.4 Мэргэжлийн зэргийн шалгалтыг дараах хэлбэрээр авна. Үүнд:

6.4.1 Тестээр мэргэжлийн онолын мэдлэгийг шалгах;

6.4.2 Асуулт хариулт бүхий албан ярилцлагаар.

6.5 Мэргэжлийн зэрэг горилогчийн мэргэжлийн зэргийн шалгалтын дүн, материалыг Мэргэжлийн зэргийн комисс хэлэлцэн гишүүдийн олонхийн саналаар зэрэг олгох, эс олгох шийдвэрийг гарган, Иргэний нисэхийн еренхий газрын даргын тушаалаар олгоно.

6.6 Мэргэжлийн зэргийн тухайн шалгалтад тэнцээгүй горилогч дараагийн эзлжит шалгалтад орж болно.

6.7 Мэргэжлийн III, II зэрэгтэй Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнууд 3 жилд нэг удаа мэргэжлийн зэрэг хамгаалах шалгалт заавал өгнө.

6.8 Мэргэжлийн I зэрэгтэй ажилтан нь 5 жилд нэг удаа мэргэжлийн зэрэг хамгаалах шалгалт өгнө.

Долоо. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл

7.1 Мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцэж зэргийн шаардлагыг хангасан ажилтнуудад мэргэжлийн зэргийн нэмэгдлийг дор дурдсанаар үндсэн цалингаас бодож тооцон 6.7, 6.8-нд заасан хугацаанд олгоно.

7.1.1 Мэргэжлийн I дүгээр зэрэг -15 хувь

7.1.2 Мэргэжлийн II дугаар зэрэг - 10 хувь

7.1.3 Мэргэжлийн III дугаар зэрэг - 5 хувь

Найм. Мэргэжлийн зэргийг бууруулах

8.1 Мэргэжлийн зэргийг дараах тохиолдолд, Мэргэжлийн зэргийн комиссын дүгнэлтийг үндэслэн Иргэний нисэхийн еренхий газрын даргын тушаалаар бууруулна. Үүнд:

8.1.1 Мэргэжлийн зэргийн эзлжит хамгаалах шалгалтад ороогүй бол;

8.1.2 Мэргэжлийн зэрэг хамгаалах шалгалтад хангалтгүй дүн үзүүлсэн бол;

8.1.3 Зэрэг тогтоолгон ажиллах хугацаандаа нислэгийн хөдөлгөөний зерчил гаргаж түүнийгээ мэдээлээгүй нуун дарагдуулсан бол;

8.1.4 Зэрэг эзэмших хугацаандаа сахилгын зерчил гаргасан бол.

8.2 Мэргэжлийн зэрэг буурсан ажилтан дараагийн мэргэжлийн зэргийн шалгалтад зэрэг горилж болно.

в. Мэргэжлийн III зэргийн шалгалтыг амжилттай ёгсен байх;
г. Англи хэлний ур чадварын талаарх ICAO-ын ангиллын 4 болон түүнээс дээш түвшний шаардлага хангасан байх.

4.1.2 Мэргэжлийн II зэрэг авахад:

- а. Нислэгийн удирдагчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй;
- б. Мэргэжлийн III зэрэгтэй байх;
- в. Нислэгийн удирдагчийн мэргэжлийн III зэрэг зээмшин 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
- г. Мэргэжлийн II зэргийн шалгалтыг амжилттай ёгсен байх;
- д. Англи хэлний ур чадварын талаарх ICAO-ын ангиллын 4 болон түүнээс дээш түвшний шаардлага хангасан байх.

4.1.3 Мэргэжлийн I зэрэг авахад:

- а. Нислэгийн удирдагчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;
- б. Мэргэжлийн II зэрэгтэй байх;
- в. Нислэгийн удирдагчийн мэргэжлийн II зэрэг зээмшсэний дагуу 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
- г. Мэргэжлийн I зэргийн шалгалтыг амжилттай ёгсен байх;
- д. Ажлын байранд тавигдах Англи хэлний шаардлага болон ICAO-ын ангиллын 4 болон түүнээс дээш түвшний шаардлага хангасан байх.

4.2 Мэргэжлийн зэрэг горилогчид 4.1-д зааснаас гадна дараах нэмэлт шаардлагуудыг тавина. Үүнд:

- а. Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зерчил гаргаагүй байх;
- б. Сүүлийн 3 жилд нислэгийн хөдөлгөөний зерчил 2-оос дээш удаа гаргаагүй байх.

4.3 Мэргэжлийн зэрэг горилогч нь доорх нөхцөлийг хангаж байвал мэргэжлийн зэрэг горилон шалгалт ёгех хугацааг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын тодорхойлолт, саналын дагуу мэргэжлийн зэргийн шалгалтын комисс дүгнэлт гарган 1 жилээр урагшуулан тогтоож болно. Үүнд:

4.3.1 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн шинэ санал, төсөл санаачлан дэвшүүлж, уг санаачилга нь зохих ур дүнгээ ёгч хэрэгжсэн;

4.3.2 Удаа дараагийн нислэгийн онцгой нөхцел, тохиолдлын үед мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажилласан.

4.4 Орон нутгийн нисэх буудлуудын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод англи хэлний шаардлага тусгагдаагүй тохиолдолд англи хэлний ур чадварын талаарх ICAO-ын ангиллын 3 болон түүнээс дээш түвшний шаардлага хангасан байна.

4.5 Мэргэжлийн зэргийг алгасуулан олгохгүй.

Тав. Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс

5.1 Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний мэргэжилтэй 7 хуний бүрэлдэхүүнтэй байх ба комиссын бүрэлдэхүүнийг Иргэний нисэхийн еренхий газрын даргын тушаалаар батална.

5.2 Мэргэжлийн зэргийн шалгалтын комиссын бүрэлдэхүүн зэрэг горилохгүй.

5.3 Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс нь мэргэжлийн зэргийн шалгалт авах огноо, үргэлжлэх хугацаа, байршилыг тогтооно.

Ес. Шилжилтийн үеийн зохицуулалт

9.1 Мэргэжлийн зэргийн тогтолцоонд бүрэн шилжих хүртэлх хугацааг шилжилтийн үе гэх ба мэргэжлийн зэргийн комисс нь мэргэжлийн зэргийн шалгалт авах график, хуваарыт шилжилтийн үеийн бусад зохицуулалтыг хийнэ.

9.2 Шилжилтийн үед хүний нөөц болон шилжилтийн үеийн бусад зохицуулалттай уялдуулан тухайн ажлын байрны шаардлагаас доогуур мэргэжлийн зэрэг бүхий ажилтан ажиллуулж болох ба уг ажилтан нь ИНД65-ын дагуу бэлтгэгдэн дадлагажсан байна.

9.3 Тухайн мэргэжилтэн, албан тушаалтны гүйцэтгэж буй ажил үүргийг харгалзан одоогийн эрхэлж буй албан тушаалд нь шаардагдах мэргэжлийн зэргийг амжилттай өгсөн шалгалтын дүнг үндэслэн олгох тухай шийдвэрийг мэргэжлийн зэргийн комисс гаргана.

Арав. Бусад зүйл

10.1 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтнууд мэргэжлийн зэргийг тодорхойлсон ялгах тэмдгийг хэрэглэх ба ялгах тэмдэг нь дүрэмт хувцасны бүрэлдэхүүн хэсэг байна

10.2 Мэргэжлийн зэрэг олгогдсон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэхэд мэргэжлийн зэргийн тусгай тэмдэглэлийг үйлдэнэ.

10.3 Энэхүү журамд заагдаагүй нөхцөл байдал үүсвэл Мэргэжлийн зэргийн шалгалтын комисс хэлэлцэн шийдвэрлэнэ.

xxx